



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/46

Аргатай

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г" дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 1.1 дэх заалт Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн 2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Хөөтөд байрлах 12199А тусгай зөвшөөрөлтэй "Монголын Алт" /МАК/ ХХК-ний Хөөтийн нүүрсний уурхайг тэжээх 35/6 квт-ын дэд станц, цахилгааны агаарын шугамын хамгаалалтын зурвасын зориулалтаар 25км урт, 30км өргөн зурвас бүхий 75,6 га газрыг МАК ХХК-д 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Т.Шуухааз), хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч (Х.Сарангэрэл) нарт даалгасугай.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч "Монголын алт МАК" ХХК-ний гүйцэтгэх захирал (Н.Цэлмүүн)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2011 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/29 тоот захирамж хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЗОЛЗАЯА

